



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 5/101

Чингис хот

Ажилд шилжүүлэн томилох тухай

Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, “Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам /код-136/-ийн 136.4.2-ийн “б” заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дүгээр тушаалаар батлагдсан “Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах журам /код-908/-ын 908.2.2-ийн “а” заалт, цагдаагийн газрын даргын зөвлөлийн 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ахлах ахлагч Ц.Сугаррагчааг Эрүүлжүүлэх, саатуулах байрны цагдаагийн үүрэгт ажлаас 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлж, 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс Замын цагдаагийн тасагт зохицуулагч цагдаагаар шилжүүлэн томилсугай.

2. Цагдаагийн ахлах ахлагч Ц.Сугаррагчаагийн албан тушаалын үндсэн цалинг Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан цалингийн шатлалын ТТ-7-4 дүгээр шатлал 562917 төгрөгөөр, цолны нэмэгдлийг 25 хувиар, онцгой нөхцөлийн нэмэгдлийг 25 хувиар, алба хаасны нэмэгдэлийг 10 хувиар тус тус бодож олгохыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

3. Шилжин томилогдсон цагдаагийн ахлах ахлагч Ц.Сугаррагчаагийн сургагч багшаар Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Х.Мөнх-Эрдэнийг томилж, ажлын байрыг хүлээлцүүлэх, албан тушаалтай нь холбоотой хууль, дүрэм, журам, эрх зүйн актуудыг танилцуулан судлуулах, мөрдүүлэх, цаг ашиглалт, сахилга ёс зүйн байдалд тогтмол хяналт тавьж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх журам /код-912/-ын дагуу богино хугацаанд ажилд нь сургаж

дадлагажуулан биелэлт үр дүнг тооцож ажиллахыг Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Х.Мөнх-Эрдэнэд даалгасугай.

4. Шинээр томилогдсон алба хаагчийг сургаж дадлагажуулсан ажлын хавтас нээж, материалжуулан, улирал тутамд материалыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Чинбаатарт хянуулж, чиглэл авч ажиллахыг сургагч багш цагдаагийн хошууч Х.Мөнх-Эрдэнэд үүрэг болгосугай.

5. Тушаалын хуулбарыг хувийн хэрэгт нь хавсаргахыг Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад П.Алтантуяад үүрэг болгосугай.

6. Тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА



Ж.БОЛД